



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 160

Чойбалсан

Г Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх Г
хөтөлбөр хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5, “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.2.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 79 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх хөтөлбөр”, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 18-1/01 тогтоолоор батлагдсан аймгийн 2024 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний 1.3 дахь заалт, “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 19/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд зориулж 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлж, төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Дэмжлэгт шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 2.48 дахь “Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Биеийн тамир, спортын газартай байгуулах орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулан батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т даалгасугай.

4. Хөтөлбөрийг чанартай зохион байгуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг олон нийтэд танилцуулж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газар (Б.Чимэддорж)-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ш.Ёл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

212401110

Аймгийн Засаг даргын 2024 оны
 01... дугаар сарын 08-ны өдрийн
 460 дугаар захирамжийн хавсралт



ҮНДЭСНИЙ БӨХИЙН СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ
 ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Д/д	Спортын төрөл	Үйл ажиллагаа	Төсөв өртөг (төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн
1.	Үндэсний бөхөөр хичээллэгчид болон барилдааныг нэмэгдүүлж, бэлтгэл сургалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтмол хийж, улсын, аймгийн, сумын цолтой бөхчүүдийн тоог нэмэгдүүлнэ	Баяр наадамд барилдах бөхчүүдийн бэлтгэлд гарах, сорилго барилдаан зардал	3,000,000	Бэлтгэл сургуулилтын тоо	1
				Хамрагдах бөхчүүдийн тоо	40
		Зүүн бүсийн Сумын Заан цолтой бөхчүүдийн барилдаан	5,000,000	Зохион байгуулах арга хэмжээний тоо	1
				Оролцох бөхийн тоо	64
		Өсвөрийн бөхчүүдийн барилдааны зардал	2,000,000	Зохион байгуулах арга хэмжээний тоо	3
				Оролцох бөхчүүдийн тоо (давхардсан тоогоор)	32
НИЙТ ДҮН		10,000,000			